# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 17 өдөр Дугаар 141 Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 55,512,001.45 (тавин таван сая таван зуун арван хоёр мянга нэг төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 13,608,847.52 (арван гурван сая зургаан зуун найман мянга найман зуун дөчин долоон төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Цагдаагийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Эрдэнэхишиг, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны дарга, цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭХИШИГ

0001771

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн
141 дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Цагдаагийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэх автомашин

| Д/д | Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Нийт гүйлт (км) | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ланд круйзер 200, Суудлын автомашин, 44-36 УБЗ улсын дугаартай, JTMCU09J804007073 арлын дугаартай. | 2007/2008 | 398,749 | 55,512,001.45 | 13,608,847.52 | 41,903,153.93 |
| **Нийт дүн** | | | | **55,512,001.45** | **13,608,847.52** | **41,903,153.93** |
| **Нийт дүн** | | | | (тавин таван сая таван зуун арван хоёр мянга нэг төгрөг дөчин таван мөнгө) | (арван гурван сая зургаан зуун найман мянга найман зуун дөчин долоон төгрөг тавин хоёр мөнгө) | (дөчин нэгэн сая есөн зуун гурван мянга нэг зуун тавин гурван төгрөг ерэн гурван мөнгө) |